



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань-Илч ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/4/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг
2021 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Т. Ган-Өлзий
Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа /Есөнхангай Аудит ХХК/
Утас: 99048891

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сэннингол сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi.audit.gov.mn

Ажл. 05.30 № 1-6/348

танай _____-ны № _____-т

“ЧАНДМАНЬ-ИЛЧ” ОНӨХХК-НЫ
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу “Чандмань-Илч” ОНӨХХК-ны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Чандмань-Илч” ОНӨХХК-ны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

1002080


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр/
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31	
1	ХӨРӨНГӨ			
1.1	Эргэлтийн хөрөнгө			
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	203,619,648.62	399,383,271.21	
1.1.2	Дансны авлага	1,292,594,526.90	891,394,200.70	
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-		
1.1.4	Бусад авлага	1,256,461.97	2,150,647.65	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-		
1.1.6	Бараа материал	538,314,400.64	500,541,242.92	
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	139,041,576.16	1,577,322,746.78	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-		
1.1.10				
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,174,826,614.29	3,370,792,109.26	
1.2	Эргэлтийн бус хөрөнгө			
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,615,532,152.20	26,091,908,026.84	
1.2.2	Биет бус хөрөнгө	2,503,458,865.79	2,615,086,123.71	
1.2.3	Биологийн хөрөнгө			
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт			
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө			
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө			
1.2.9				
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,118,991,017.99	28,706,994,150.55	
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,293,817,632.28	32,077,786,259.81	
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
2.1	Өр төлбөр			
2.1.1	Богино хугацаат өр төлбөр			
2.1.1.1	Дансны өглөг	231,081,317.72	137,372,953.83	
2.1.1.2	Цалингийн өглөг			
2.1.1.3	Татварын өр	169,108,776.09	100,544,866.56	
2.1.1.4	НДШ – ийн өглөг			
2.1.1.5	Богино хугацаат зээл	300,899,222.79	600,000,000.00	
2.1.1.6	Хүүний өглөг			
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг			
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	15,577,614.38	659,083,178.58	
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/			
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр			
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр			

2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	716,666,930.98	1,497,000,998.97
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,841,366,587.73	1,918,465,293.49
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		11,328,513,821.00
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,841,366,587.73	13,246,979,114.49
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,558,033,518.71	14,743,980,113.46
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	15,459,856,685.46	15,459,856,685.46
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,696,314,963.48	7,731,578,024.44
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	512,609,701.20	512,609,701.20
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-5,932,997,236.57	-6,370,238,264.75
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,735,784,113.57	17,333,806,146.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,293,817,632.28	32,077,786,259.81

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,954,038,758.77	7,871,367,197.48
2	Борлуулалтын өртөг	7,161,659,233.78	7,644,083,660.35
3	Нийт ашиг(алдагдал)	792,379,524.99	227,283,537.13
4	Түрээсийн орлого	6,088,727.30	12,975,272.71
5	Хүүний орлого	2,236,893.04	1,417,951.58
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	20,316,579.86	2,765,428.04
9	Борлуулалт, маркетингийн зардал	153,263,338.82	159,358,386.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	523,507,120.45	525,536,277.40
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	83,938,910.67	86,297,033.19
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,579,914.33	-111,072.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-447,633,110.54	-480,963.25
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-127,690,273.34	45,353,341.87
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-512,431,114.30	-481,988,201.42
19	Орлогын татварын зардал	14,425,126.57	141,795.16
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-526,856,240.87	-482,129,996.58
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-526,856,240.87	-482,129,996.58
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-	
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,924,821,597.13	8,121,022,172.88	12,535,035,088.33	-5,832,058,580.67	17,748,820,277.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				425,917,585.21	425,917,585.21
Залруулсан үлдэгдэл	2,924,821,597.13	8,121,022,172.88	12,535,035,088.33	-5,406,140,995.46	18,174,737,862.88
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-526,856,241.11	-526,856,241.11
Өмчид гарсан өөрчлөлт	12,535,035,088.33		-12,022,425,387.13		512,609,701.20
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдэл		-424,707,209.40			-424,707,209.40
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,696,314,963.48	512,609,701.20	-5,932,997,236.57	17,735,784,113.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				44,888,968.40	44,888,968.40
Залруулсан үлдэгдэл	15,459,856,685.46	7,696,314,963.48	512,609,701.20	-5,888,108,268.17	17,780,673,081.97
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-482,129,996.58	-482,129,996.58
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдэл		35,263,060.96			35,263,060.96
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,731,578,024.44	512,609,701.20	-6,370,238,264.75	17,333,806,146.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,370,127,020.40	11,013,816,503.10
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,625,293,335.59	9,750,431,447.77
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	292,500.00	
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	593,300,000.00	1,036,500,000.00
	Бусад мөнгөн орлого	151,241,184.81	226,885,055.33
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,069,819,929.39	10,446,553,124.34
	Ажиллагчдад төлсөн	1,909,335,901.25	2,302,679,202.15
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	605,978,506.67	721,453,798.13
	Бараа материал худалдан авахад төлсөн	3,535,195,537.37	3,878,428,718.74
	Ашиглалтын зардалд төлсөн	825,553,411.58	956,870,008.10
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	545,651,946.80	595,255,694.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	440.00
	Татварын байгууллагад төлсөн	1,036,656,569.82	797,914,590.13
	Даатгалын төлбөрт төлсөн	9,971,973.00	242,884,804.00
	Бусад мөнгөн зарлага	601,476,082.90	951,065,869.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,300,307,091.01	567,263,378.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	468,919,720.00	594,361,876.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	441,263,470.00	553,520,876.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	27,656,250.00	40,841,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(468,919,720.00)	-594,361,876.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	700,000,000.00	900,000,000.00

Чандмань-Илч ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	700,000,000.00	900,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,542,635,528.33	677,137,880.17
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,542,635,528.33	677,137,880.17
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-842,635,528.33	222,862,119.83
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	11,248,157.02	195,763,622.59
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	214,867,805.6	203,619,648.62
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	203,619,648.62	399,383,271.21

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2019 оны гүйцэтгэл	2020 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	ОРЛОГО:					
1	Дулаан	5,228.5	6,068.4	5,960.1	(108.3)	98.2%
2	Цэвэр ус	777.2	810.7	790.8	(19.9)	97.5%
3	Бохир ус	483.1	530.5	472.8	(57.7)	89.1%
4	Бусад	1,532.2	600.0	793.6	193.6	132.3%
5	Хөнгөлөлт	(37.6)	(100.0)	(82.5)	17.5	82.5%
	Дүн	7,983.4	7,909.7	7,934.8	25.1	100.3%
B	ЗАРДАЛ:	-	-			
1	Цалин түүнтэй адилтгах зардал	2,133.0	2,874.1	2,573.9	(300.2)	89.6%
2	ТУЗ нарийн бичгийн цалин	8.6	9.1	9.8	0.7	108.1%
3	ТУЗ урамшуулал	3.6	7.2	4.8	(2.4)	66.7%
4	НДШ	315.1	467.3	383.4	(83.9)	82.0%
5	Нүүрс	1,310.5	1,806.3	1,476.1	(330.1)	81.7%
6	Салаа зам арчлалт	24.3	23.4	23.7	0.3	101.2%
7	Цахилгаан	745.1	986.1	854.0	(132.1)	86.6%
8	Хөдөлмөр хамгаалал	82.6	176.9	106.3	(70.6)	60.1%
9	Шатахуун	261.4	285.9	304.9	19.0	106.7%
10	Шууд бус материал	13.0	23.8	15.2	(8.6)	64.0%
11	Урсгал засвар	458.4	350.0	527.8	177.8	150.8%
12	Хог хаягдал	3.6	4.4	3.6	(0.9)	80.2%
13	Бичиг хэрэг	11.5	9.8	11.5	1.7	117.3%
14	Интернэт, шуудан холбоо	20.3	30.0	26.1	(3.9)	86.9%
15	Томилолт	21.3	27.0	17.1	(9.9)	63.2%
16	Зар сурталчилгаа	3.3	4.0	5.0	1.0	126.0%
17	Сургалт	10.6	16.5	6.1	(10.4)	37.0%
18	Авто тээврийн даатгал	6.2	7.0	9.5	2.5	135.4%
19	Үл хөдлөх хөрөнгийн татвар	10.3	12.9	11.1	(1.8)	86.1%

Чандмань-Илч ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

20	Автомашины татвар	3.8	2.0	3.5	1.5	175.0%
21	Зээлийн хүү	61.6	3.8	80.9	77.1	2128.9 %
22	Газрын төлбөр	0.1	1.8	6.8	5.0	378.1%
23	Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,189.5	1,220.1	1,336.9	116.8	109.6%
24	Хангамжийн материал	54.1	42.5	39.6	(2.9)	93.3%
25	Төсөвт	918.9	229.2	330.4	101.2	144.2%
26	Бусад	167.8	60.2	160.8	100.5	266.9%
27	Үйл ажиллагааны бус	657.4	94.2	87.8	(6.4)	93.2%
	Дүн	8,495.8	8,775.6	8,416.8	(358.8)	95.9%
В	2020 оны татварын өмнөх ашиг	(512.4)	(866.0)	(482.0)	384.0	55.7%
Г	ААНОАТ	14.4	-	0.1		
Д	2020 оны цэвэр ашиг	(526.9)	(866.0)	(482.1)	383.9	55.7%

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Д.Эрдэнэбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлэх, хөрөнгүүд бодит үнэ цэнээр бүртгэгдээгүй, авлагын үлдэгдлийг баталгаажуулах, аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 01-нээс 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Есөнхангай Аудит ХХК-ийн аудиторуд Т.Оюунтуяа, Д.Баярмаа, Д.Батсайхан, М.Одцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж
- Хүн ам үйлдвэрлэлийн хэрэгцээний ус хуримтлуулан ариутгаж түгээх ажиллагаа
- Бохир ус, хаягдал цэвэрлэгээ, ариутгалын үйлчилгээ
- Зочид буудал
- Дэлгүүр
- Тоног төхөөрөмж угсралтын болон барилга угсралт, магистраль инженерийн шугам сүлжээ угсрах ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чандмань-Илч ОНӨХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны газраас дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 7,913.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 79.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,783.97 сая төгрөгөөр буюу 58.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	203.62	399.38	195.76
Авлага	1,293.85	893.54	-400.31
Урьдчилгаа	139.04	1,577.32	1,438.28
Бараа материал	538.31	500.54	-37.77
Үндсэн хөрөнгө	15,615.53	26,091.91	10,476.38
Биет бус хөрөнгө	2,503.46	2,615.09	111.63
Нийт хөрөнгийн дүн	20,293.82	32,077.79	11,783.97
Өр төлбөр	2,558.03	14,743.98	12,185.95
Эздийн өмч	17,735.78	17,333.81	-401.97
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,293.82	32,077.79	11,783.97

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, урт хугацаат ерийн дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 399.4 сая төгрөг болж 195.8 сая төгрөгөөр өссөн нь авлагын дансны үлдэгдэл буурсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 893.5 сая төгрөг болж 400.3 сая төгрөгөөр буурсан гол шалтгаан нь 2019 онд Аймгийн засаг даргын тамгын газраас Мандах наран-4 хорооллын шугам сүлжээний тендерийн ажлын санхүүжилтээс 535.0 сая төгрөг дутуу орж ирсэн нь 2020 онд төлөгдөж дууссанаар дансны авлагыг бууруулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26,091.9 сая төгрөг болж 10,476.4 сая төгрөгөөр өссөн нь 2020 онд хөрөнгө 12,640.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,025.9 сая төгрөгөөр хасагдсан байна. Нэмэгдсэн үндсэн хөрөнгийн 11,131.2 сая төгрөг нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн шугам сүлжээ, Алтанширээ, Хатанбулаг, Даланжаргалан сумдын төвлөрсөн зуух, шугам сүлжээ, барилга байгууламжийг бүртгэж авсан байна.

Биет бус хөрөнгө 2,615.1 сая төгрөг болж, 111.6 сая төгрөгөөр өссөн нь 2020 онд газар 75.8 сая төгрөгөөр, программ хангамж 56.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Урьдчилж төлсөн зардал 1,577.3 сая төгрөг болж өмнөх оноос 1,438.3 сая төгрөгөөр их гарсан нь орон нутгийн өмчийн газраас зарласан “Дэлгэрэх сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр ус, бохир усны шугам сүлжээ, барилга, байгууламж барих ажил”-ын тендерт шалгарч гүйцэтгэж байгаатай холбоотой байна. Тус ажил нь 2021 онд дуусах буюу он дамжин гүйцэтгэгдэж байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 14,744.0 сая төгрөг болж 12,186.0 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогыг хойшлуулсан орлогоор бүртгэхтэй холбоотой урт хугацаат өр байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 17,333.8 сая төгрөг болж 402.0 сая төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны алдагдлаас шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 7,731.6 сая төгрөг болж 35.3 сая төгрөгөөр буурсан нь данснаас хасагдсан хөрөнгөтэй холбоотой байна.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Чандмань-Илч ОНӨХХК-ийн дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Чандмань-Илч ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 07 дугаар тогтоолоор байгууллагын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд 2020 оны 3 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж тайлант оны нийт орлогыг 7,909.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 8,775.6 сая төгрөгөөр, цэвэр алдагдлыг 865.9 сая төгрөгөөр тогтоосон байна. Мөн их засвар, хөрөнгө оруулалтад 436.6 сая төгрөг, худалдан авах бараа ажил үйлчилгээнд 2,510.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 7,934.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,339.7 сая төгрөгийн зардал гарган, 405.0 сая төгрөгийн цэвэр алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, түрээсийн орлого, хүүгийн орлого, бусад орлогоос бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	мян.төг	7,983.4	7,909.7	7,934.8	25.1	0.3
	Үүнээс: Цэвэр борлуулалт						
2	Нийт зардал	мян.төг	8,495.8	8,775.6	8,416.8	-358.8	-4.1
3	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	-526.9	-866.0	-482.0	384.0	44.3

Нийт орлогын гүйцэтгэл 7,934.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 25.1 сая төгрөг буюу 0.3 хувиар давж биелсэн нь 3 тендерт илүү оролцсон, мөн үйл ажиллагааны бус орлогод

44.6 сая төгрөг нь хойшлогдсон орлогоос тайлант хугацаанд ногдох орлогыг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,416.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 358.8 сая төгрөг буюу 4 хувиар хэмнэгдсэн байна. 2020 оны 6-р сард цэвэрлэх байгууламжид 11 ажлын орон тоо, 10-р сард Сайншанд салбарын эх үүсвэр-2-т 10 ажлын орон тоог шинээр ашиглалтад оруулна гэж тооцон төсөвлөсөн ба ашиглалтад ороогүйгээс цалингийн зардал 300 сая төгрөг, нийгмийн даатгалын зардал 84 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардал 70 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

2020 онд 866.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллана гэж төлөвлөгдсөнөөс 482.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Зардал 384.0 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан явдал нь алдагдлыг бууруулах үндсэн шалтгаан болж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

"Чандмань-Илч" ОНӨХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 31 дүгээр тогтоолоор батлагдсаны дагуу хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг 2020 онд 3 удаа зохион байгуулж 6 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой дүрэм, журам батлаагүй байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд зориулсан төсөв батлагдаагүй, ТУЗ нь гүйцэтгэх захиралтай хийсэн гэрээнд ТУЗ-ийн гишүүнд улирал бүр 0.2 сая төгрөгийн урамшуулал олгохоор тусгаж, тайлант хугацаанд 4.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 128 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт					
Албан шаардлага	2		1		50
Зөвлөмж	7		5		71
Нийт дүн	9		6		66

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,554.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,482.9 сая төгрөгийн алдааг залруулж, 70.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан 11,449.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэхдээ орлогоор бүртгэлгүй эздийн өмчийн бусад хэсэг дансанд авсныг НББОУС-20 стандартын дагуу бүртгэж залруулав.
2. Авлага 33.9 сая төгрөгөөр кредит үлдэгдэлтэй тайлагнагдсаныг өр төлбөрт шилжүүлэв.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

1.1. Илрүүлэлт:

Өмнөх оны аудитаар 2 албан шаардлагад 4 зөрчил, 7 зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөрчил, 5 зөвлөмж нь хэрэгжсэн байна. Тайлант хугацаанд хэрэгжээгүй зөвлөмжөөс давтан гарсан асуудал нь тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор тооцоогүйгээс ашиг алдагдал, татварын өр, зардал буруу илэрхийлэгдэх эрсдэл үүссэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29-р зүйл, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтуудад нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд татварын дүн буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж

Татварын ерөнхий хууль, ААНОАТ тухай хууль, Сангийн Сайдын 2020 оны 144 тоот тушаалын дагуу санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хооронд үүссэн зөрүүг зохицуулах тайланг гаргаж, тайлант үеийн болон хойшлогдсон татварын дүнг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 393 нэр төрлийн 1.0 тэрбум төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй байгаа нь СТОУС-ын 17.49 "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25, 77 дугаар зүйлийн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Эрсдэл:

Хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлээгүйгээс нягтлан бодох бүртгэл буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж

Үлдэх өртөггүй ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг цаашид ашиглах бол ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, дахин үнэлгээ хийлгэх.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийн дагуу өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх саналыг ТУЗ-д хүргүүлж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Цалингийн санг НД-ын байгууллага, Татварын албанд тайлагнахдаа зөрүүтэй тайлагнасан байна. Тухайлбал: НД-ын байгууллагад 2 ажилтанд 1.2 сая төгрөгийн цалинг илүү тайлагнаж, 3 ажилтны 0.4 сая төгрөгийн цалинг тайлагнаагүй орхигдуулсан байна. Энэ нь НД-ын тухай хуулийн 17-р зүйл, ХХОАТ-ын тухай хуулийн 25-р зүйлийн заалтуудад нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Хуулиа мөрдөөгүйгээс алданги торгуульд орох

3.3. Өгсөн зөвлөмж

Татвар, нийгмийн даатгалын байгууллагад цалин, түүнтэй адилтгах орлогын тайлагнаж буй дүнг бүртгэлээрх дүнтэй тулгаж, тухай бүр нь хянаж байх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дутуу тайлагнасан 3 ажилтны НДШ-ийн тайланг засварлах, овог андуурч тайлагнасан 2 ажилтны илүү цалинг залруулж ажиллана.

4. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

4.1. Илрүүлэлт:

Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаал Санхүүгийн тайлангийн үндсэн бүрэлдэхүүн болох Өмчийн өөрчлөлтийн тайланг бүрэн тайлагнаагүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд тодруулгаарх эцсийн үлдэгдлийн дүнгээс зөрүүгүй боловч өссөн буурсан, тодруулах шаардлагатай үзүүлэлтээр нь үнэн зөв задалж тодруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 1 дүгээр хавсралт Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд: 4.Өмчийн өөрчлөлтийн тайлан нь эздийн өмчид гарсан аливаа өөрчлөлтийн хэмжээг дараах байдлаар, 2 жилээр толилуулна гэсэн заалт болон НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" гэсэн заалттай нийцээгүй, бодитой оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

4.2. Эрсдэл:

Хэрэглэгчид үнэн зөв мэдээллээр хангагдаж чадахгүй байх.

4.3. Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын батлагдсан 2017 оны 361 дүгээр тушаал, санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх зааврыг мөрдөж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын хугацаанд санхүүгийн тайланг засварлаж ажиллана. Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Чандмань илч ОНӨХХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДГА-2021/4/СТА-ОНӨХХК
Шалгагдсан байгууллагын нэр:	Чандмань илч ОНӨХХК		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэхдээ орлогоор бүртгэлгүй эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн.	11,449.0	Залруулах	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
2	Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хооронд үүссэн зөрүүг зохицуулах тайланг гаргаагүйгээс татварын дүнг үнэн зөв тодорхойлоогүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
3	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 393 нэр төрлийн 1.0 тэрбум төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
4	Цалингийн санг НД-ын байгууллага, Татварын албанд тайлагнахдаа зөрүүтэй тайлагнасан байна.	1.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
5	Санхүүгийн тайлангийн үндсэн бүрэлдэхүүн болох Өмчийн өөрчлөлтийн тайланг бүрэн тайлагнаагүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд тодруулгаарх эцсийн үлдэгдлийн дүнгээс зөрүүгүй боловч өссөн буурсан, тодруулах шаардлагатай үзүүлэлтээр нь үнэн зөв задалж тодруулаагүй байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
6	Авлагын 14.6 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	14.6	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
7	Авлагын үлдэгдэл кредит үлдэгдлээр буюу 33.8 сая төгрөгийн авлага өглөг буурч тайлагнагдсан.	33.8	Залруулах	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
8	Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй ТБОНӨБАУХА тухай хуулийг мөрдөж ажиллаагүй 55.5 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллаагүй	55.5	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Б. Ган-Эрдэнэ
ДҮН		11,554.6			